

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

“ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ” СУРГАЛТ БОЛЛОО

Батлан хамгаалах яамны харьяа байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Батлан хамгаалах яамны Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сургалтыг Цэргийн төв эмнэлгийн хурлын танхимд зохион байгууллаа.

Энэхүү сургалтыг Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч, яамны төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн дарга бригадын генерал Ж.Болдбаатар нээж, сургалтад оролцогч Цэргийн төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд болон харьяа байгууллагын эмч нарт эрхэлсэн ажил албандаа хариуцлагатай, ёс зүйтэй хандаж, үйлчлүүлэгчдэд хүнлэг, хүнд сурталгүй үйлчилж байхын чухлыг сануулсан юм.

Сургалтын үеэр ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга, анагаах ухааны доктор М.Цэрэнбат эмнэлгийн эрх зүйн зөрчил



ба ёс зүйн талаар илтгэл тавьсан бол БХЯ-ны ХШҮДАГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл ахуйн хяналтын ахлах мэргэжилтэн дэд хурандаа С.Нэргүй эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн нийтлэг зөрчлийн талаар мэдээлэл өгч, оролцогчидтой харилцан ярилцаж, санал бодлоо солилцож сургалтыг үр дүнтэй өрнүүлээ.



УРАН БҮТЭЭЛЧ С.СҮХ-ОДЫН “100+1” СЭДЭВТ УРАН БҮТЭЭЛИЙН ҮЗЭСГЭЛЭН



Монгол цэргийн музей нь монгол цэргийн түүхийг үзэгч түмэнд сурталчлан таниулах арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулсаар ирсэн билээ. Үүний нэгэн жишээ нь “Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 101 жилийн ойг тохиолдуулан залуу уран бүтээлч, барималч С.Сүх-Одын уран бүтээлээс дээжлэн “100+1” сэдэвт үзэсгэлэнг дэглэн толилуулж байна.

Тус үзэсгэлэнд орчин цагийн Зэвсэгт хүчний түүхэн хөгжил, түүхэн тэмцлийн гол удирдагчдын бодит дүр бүхий 15 нэр төрлийн 101 уран баримал, рельефийг дэглэн үзүүлж байгаа юм.

Бодит дүр олонтой, цэргийн гол удирдагчдын түүхэн дүрийг мөнхлөн тухайн үеийн дүрэмт хувцас бүхий аравтын зохион байгуулалттай салаа цэрэг, зэвсэг техникүүдийг цогцоор үзүүлж байгаагаараа онцлогтой эл үзэсгэлэн энэ сарын 21-27-ны өдрүүдэд Монгол цэргийн музейд дэглэгдэж байна.

ЗАРЛАЛ

Зэвсэгт хүчний цэргийн алба хаагч та бүхнийг цэргийн мэргэжлийн I зэрэг эзэмших шалгалтад хамрагдахыг урьж байна.

Шалгалтыг 2022 оны 4 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд явуулах бөгөөд 2021 онд шинээр батлагдсан “ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ”-ыг судлан танилцаж, цэргийн мэргэжлийн I зэрэгт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан цэргийн алба хаагчид холбогдох баримт бичиг, материалаа бүрдүүлэн 4 дүгээр сарын 14-ний өдрийн дотор харьяа салбар комиссоор уламжлуулан Цэргийн мэргэжлийн зэргийн төв комисст ирүүлнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг training@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3573, 92114690 утсаар холбогдож тодруулж болно.

“ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ”-тай БХЯ-ны цахим хуудасны хууль, эрх зүйн булан буюу <https://mod.gov.mn/тушаал-шийдвэр/> холбоосоор орж танилцана уу.

ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ТӨВ КОМИСС

“ЦАХИМ ГҮЙЛТ-101 КМ” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, идэвхтэй хөдөлгөөний энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор ангийн “Ахлагчийн зөвлөл”-

байх шаардлагыг удирдамжид тусгасан юм. Аянд нийт 93 офицер, ахлагч, ажилчин алба хаагчид хамрагдаж нийлбэр дүнгээр 6944 км замыг туулснаас 27 цэргийн алба хаагч “Цахим гүйлт-101 км” гэсэн болзлоо биелүүлсэн байна.

Эдгээрээс эрэгтэй ангилалд I байрт Цэргийн цагдаагийн ротын салааны захирагч дэслэгч Т.Жамбалсанжид, II, III байрт Нэгдсэн агуулахын



өөс “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан “Цахим гүйлт-101 км” аяныг энэ сарын 1-16-ны өдрийг хүртэл 15 хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Аяныг зохион байгуулахын тулд нийт бие бүрэлдэхүүнд гүйлтийн “STRAVA” апплейкшныг гар утсанд нь суулган өгч “Гүйгчид 032” клубийг үүсгэн тамирчдыг нэгтгэснээр хүн нэг бүрийн гүйлт, алхалтыг хянах боломжийг бүрдүүлсэн бөгөөд тус аянд офицер, ахлагч нар бүрэн хамрагдаж, аяны турш хамгийн багадаа 101 км гүйлт, алхалтыг хийсэн

харуулчин ахлагч н.Энхтулга, Ө.Батзориг нар шалгарлаа.

Цаашид бие бүрэлдэхүүнийг биеийн тамираар тогтмол хичээллэж эрүүл мэндээ дэмжих, энгийн дасгал болох алхалт, гүйлтээр хичээллэхийг уриалж амьдралд нь хэвшил болгох зорилгоор “Цахим гүйлт”-ийн аяныг тогтмолжуулж долоо хоног, сараар дүгнэж, тухайн хугацаанд хамгийн их гүйж, алхсан бүрэлдэхүүнийг шагнаж урамшуулж байхаар төлөвлөж байна.

Тэргүүн ахлагч Б.БАТТУЛГА